



Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН - 2015

Мэндчилгээ



Монгол Улсын бизнес, хувийн хэвшлийнхний гол төлөөллийн байгууллага болсон МҮХАҮТ-Удирдах зөвлөлийн нийт гишүүд, та бүхний төлөөлж буй хувийн хэвшил болон төрийн нийт компани, ААН-үүд, Монголын бизнес эрхлэгчид болон Танхимтай харилцагч төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч Та бүхэн Сар шинэдээ сайхан шинэлэв үү.

Өнгөрсөн Модон хонь жил бидэнд хямрал, хүндрэлийг дагуулсан он байлаа. Гэвч бизнесийнхэн маань өөрсдийн туулсан туршлага, ололт амжилт, суусан хэт хэтээрээ даван тууллаа. Санхүүгийн шинэчлэлийг дэмжих жил болгон зарласан өнгөрсөн онд төр, засгаас Эдийн засгийн Ил тод байдлыг дэмжих хууль, Өршөөлийн тухай хууль батлагдан гарч, энэ хуулийн хүрээнд бизнесийнхэн 14,4 их наяд төгрөгийн татвар, орлого, хөрөнгөө ил болгож төр, засгаас олгож буй хөнгөлөлт, чөлөөлөлтийг бүрэн дүүрэн ашиглаж эдийн засгийн өршөөлийг хүртлээ.

Энэ оны эхнээс НӨАТ-ын буцаан олголтын механизм үйлчилж, манай улсад мөнгө, санхүүгийн шинэчлэл хийгдэх эх суурь тавигдаж, ингэснээр татварын бааз суурь, төлөлт нэмэгдэн, далд эдийн засаг хумигдан, улс орны хөгжил зах зээлийнхээ жам ёсоор урагшаа явах дардан зам бий болж байна. Одоо бидэнд дотоод засаглалаа сайжруулах биднээс шалтгаалах ажлын шинэ он ирж байна.

Мөн өнгөрсөн онд МҮХАҮТ-ын 55 жилийн ой тохион Танхимын нийт ажилтан, ажилчид, 21 аймаг дахь МҮХАҮТ-ын салбар Танхимын ажиллагсад, Удирдах зөвлөлийн гишүүд бидэнд маргаашийн ирээдүйд хөтлөх урам зориг, эрч хүч өгсөн дэмжлэгийн он байлаа. Бидний төлөвлөгөө 88 хувьтай биелж, санхүүгийн үзүүлэлт эерэг гарсан амжилттайгаар үдэж байна.

Гал бич жилд бидэнд хийх ажил их байна. Манай улсад АСЕМ-ын чуулга уулзалт болж айлчин гийчнээр дүүрэн байж, үүнтэй зэрэгцэн төрийн түшээдээ сонгох хариуцлагын жил ирж байна.

Танхимын хувьд гишүүд, бусад бизнес эрхлэгчид, харилцагчид, дэмжигчиддээ үзүүлдэг үйл ажиллагаагаа улам сайжруулах Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх зэргээр олон ажил хүлээж байна. Тиймээс энэ он Их Бүтээн байгуулалтын он жил байж, олз омог, ашиг орлого буян дэлгэрэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье!

**МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙЛӨГЧ**

Б.ЛХАГВАЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД



АПУ ХК-ний
Гүйцэтгэх захирал
С.ЭРДЭНЭБИЛЭГ



Барс групп ХХК-ний
Захирал
Ч.АМАРБААТАР



Бридж группийн
Ерөнхийлөгч
С.СЭДВАНЧИГ



Говь ХК-ний
Тэргүүн дэд захирал
Д.НАРАНБААТАР



Жүр Үр ХХК-ний
Ерөнхий захирал
Б.МӨНХЗУЛ



Коёотэ ХХК-ний
захирал
Д.БЯМБАСАЙХАН



Макс группийн
Ерөнхийлөгч
Д.ГАНБААТАР



Мобиком корпораци
ХХК-ний Хууль эрх зүй,
бодлого зохицуулалт
хариуцсан захирал
Ц.ЭНХБАТ



Монгол Глобал ХХК-ний
Ерөнхий захирал
Б.ГАНБАЯР



Ган Хийц ХК-ний
Ерөнхий захирал
М.ДАВААСҮРЭН



НВЦ ХХК-ний
Ерөнхий захирал
Ц.БААТАРБИЛЭГ



Номин Холдинг ХХК-ний
Ерөнхий захирал
Ш.БАЯРСАЙХАН



Нью Жуулчин Турс ХХК-ний
Ерөнхий захирал
Ш.НЭРГҮЙ



М Си Эс Группийн
Захирлуудын
зөвлөлийн дарга
Ж.ОДЖАРГАЛ



ОБ Пластик ХХК-ний
Ерөнхий захирал
Ж.ОТГОНБАЯР



Өгөөж-Чихэр Боов ХХК-ний
Ерөнхий захирал
С.ТҮМЭНГЭРЭЛ



UFC группийн
Ерөнхий захирал
О.АМАРТҮВШИН



Наран Трейд ХХК-ний
Захирал
Д.УДВАЛ



Төв аймаг дахь
ХАҮТ-ын дарга
Ц.ЖАМБАЛСҮРЭН



Хатан сулжээ ХХК-ний
Ерөнхий захирал
Б.БАДАМХАНД



Энсада холдинг ХХК-ний
Ерөнхий захирал
Ө.БОЛДСАЙХАН

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Монголын мэргэшсэн
нягтлан бодогчдын
институтын дэд захирал
М.ЭРДЭНЭЖАРГАЛ



Монголын олон
улсын ба үндэсний
арбитрын арбитрч
Б.БАТХУЯГ



Очир угалз
эрсдэлийн шийдэл ХХК,
Арбитрч
Г.ХОНГОР



Тэгш хэм
групийн захирал
Д.ЦЭЦЭГСҮРЭН



Улаанбаатар аудит
корпораци ХХК-ий захирал
Б.ОСОРГАРАВ



Хүлэгт хүннү аудит ХХК-ий
аудитор, үнэлгээчин
И.ГҮРРАГЧАА



Юдентакс тин аудит ХХК-ий
ерөнхий аудитор
Э.НИНЖДУЛАМ

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



Дарга
М.ОЮУНЧИМЭГ



Орлогч дарга
М.САРАНДАВАА



Ерөнхий нарийн
бичгийн дарга
Э.ОЮУНТЭГШ

МҮХАҮТ-ЫН ХАМТ ОЛОН




ГИШҮҮНЧЛЭЛ

2015 онд нийтдээ 142 компани шинээр Төв танхимын гишүүн болж нийт гишүүдийн тоо 1000 боллоо.


2015 оны шинэ гишүүд	Тоо	%
Diamond	10	7%
Platinum	7	5%
Gold	21	15%
Classic	104	73%
Нийт	142	

2015 оны нийт гишүүд	Тоо	%
Diamond	147	15%
Platinum	55	6%
Gold	116	12%
Classic	663	66%
Сурвалжлагч гишүүн	19	2%
Нийт	1000	

Шинэ гишүүдийн салбарчилсан бүтэц



Төв танхимын 2015 оны нийт гишүүд



■ 2015 оны шинэ гишүүд

- Элсээд нэг жил болсон гишүүн байгууллагууд дээр очиж танилцах аялалыг Юу Ди Эс, Аржма Мөнх ХХК, Шутц ХХК, Грийн Химистри ХХК, Сэлбэ Плаза ХХК, Люкс Таун ХХК, Нийслэл өргөө ХХК, Евро фарм ХХК, Москва Комплекс ХХК, Шнайдер Электрик ХХК, Их аян Өргөө ХХК, SBN ХХК, Наран косметикс ХХК, Итозмон ХХК, ШУТЦ" ХХК зэрэг компани дээр тус тус хийсэн.
- Оны онцлох аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах аянг АПУ ХК, НВЦ ХХК, Баянгол эмнэлэг ХХК, Витафит ХХК, Уул уурхайн үндэсний олборлогч ХХК, Эрин интернэшнл ХХК, Номин Констракшн Девелопмент ХХК, Бишрэлт Групп, орон нутагт Дархан Уул аймгийн Монгол алтан тос ХХК, Дархан Нэхий ХХК, Орхон аймгийн Эрдэнэт хивс ХХК, Эрдэнэт Үйлдвэр ХХК зэрэг компани дээр хийсэн.

БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

Бодлогын өмгөөллийн чиглэлээр 2015 онд **15** хууль, бодлогын бичиг баримт дээр ажиллаж санал өгсөн бөгөөд **11** бодлогын бичиг баримт, хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан, **7** хэлэлцүүлэг зохион байгуулж, **10** мэдэгдэл гаргасан байна. Эдгээрээс дурдвал: 15 хуулийн төслүүд, бодлогын баримт бичгүүд дээр ажиллаж, санал боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

№	Санал	Тайлбар
1.	Гаалийн тухай хуулинд гарал үүслийн гэрчилгээний тухай заалт дахин оруулах тухай	Батлагдсан. 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2.	Гаалийн татвар, тарифын тухай хууль	
3.	Үйлдвэржилтийн жилийг дэмжиж импортын зарим барааны гаалийн татварыг нэмэгдүүлэх тухай санал	Батлагдаж Засгийн газрын 332, 333-р тогтоол 2015 оны 8-р сарын 17-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
4.	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих хуулийн төсөл	Батлагдсан. Хэрэгжиж байна.
5.	Худалдааны хуулийн төсөл	УИХ-ын 2 дахь хэлэлцүүлгийн шатандаа явж байна.
6.	Хөдөлмөрийн хуулийн төсөл	Саналаа өгсөн.
7.	Жижиг дунд үйлдвэрийн хуулийн төсөл	Батлагдаагүй
8.	“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах тухай” хуулийн төсөл	Саналаа өгсөн. Хэлэлцлийн шатанд явж байна.
9.	Арбитрын хууль	
10.	Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль	
11.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль” болон “Өмгөөллийн тухай” хуулийн нэмэлт өөрчлөлт болон шинэчилсэн найруулгын төсөл	
12.	“Эрүүгийн хууль”-ийн төсөлд хуулийн этгээдэд оногдуулах ял шийтгэлийн талаар	
13.	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Батлагдсан.
14.	“Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ын шинэчилсэн төсөл	Батлагдаагүй.
15.	Хэмжилзүйн тухай хууль	Санал өгсөн. УИХ-аар дэмжигдсэн.

ЭДИЙН ЗАСГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг 7 сард батлуулахад идэвх санаачилгатай оролцсон. Мөн энэ хуулийг бизнес эрхлэгчдэд таниулан сурталчлах чиглэлээр Танхимын удирдлагын ил захидал болон уриалга зэргийг цахим сайтууд, сонин хэвлэл мэдээллийн байгууллагаар цацах, телевиз, радиод хуулийн талаарх мэдээлэл, ярилцлага өгөх зэргээр ажилласан.

Уг хууль, хуулийг хэрэгжүүлэх журам, аргачлалын талаарх сургалтуудыг Сангийн яам, Татвар болон Гаалийн Ерөнхий газар, Нийгмийн Даатгалын Ерөнхий газар, Улсын Бүртгэлийн Ерөнхий газартай хамтран зохион байгуулсан. Нийт **350** орчим бизнес эрхлэгчдийг хамруулсан.

Энэхүү хуулийн асуудлаар МҮОНТ-ын нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан ба танхимын дэргэдэх зөвлөл болон гишүүдээс нийт 12 компанийг оролцуулсан.

НЭМЭГДСЭН ӨРТӨГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ

НӨАТ-ын тухай хуулийн өөрчлөлтөд эцсийн хэрэглэгч нь иргэн гэдэг ойлголт тусгагдаж. 2016 оны 1-р сарын 1-ээс хууль хэрэгжиж худалдан авалт хийсэн иргэн НӨАТ-ынхаа 2 хувийг буцааж авах эрх, сугалаанд орох боломж бүрдсэн. НӨАТ төлөгч нарт зориулсан сургалтыг Гааль, татварын Ерөнхий газар (ГТЕГ)-аас хамтран зохион байгуулсан.

БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ, ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГТ ОРЖ АЖИЛЛАСАН:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
2. Татварын багц хууль
3. Худалдааны хууль
4. Жижиг дунд үйлдвэрийн хууль
5. Төрөөс баримтлах аж үйлдвэрийн бодлогын стратеги төлөвлөгөө
6. Стандартчилал итгэмжлэл техникийн зохицуулалтын тухай хууль
7. Чанарын бодлого, чанарын хөтөлбөр
8. Органик хүнсний тухай хууль
9. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль
10. “Монгол Чацаргана” газарзүйн заалтыг хэрэгжүүлэх ажлын хэсэг
11. Чацарганы шүүсний стандартыг тогтоох

ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД:

1. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг
2. Хөдөлмөрийн хуулийн төслийн талаарх хэлэлцүүлэг
3. “Оюуны өмч ба зөрчил сэдэвт төр, хувийн хэвшлийн хэлэлцүүлэг
4. “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай” хууль болон НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал

5. “Бизнес ба авлига” сэдвээр Улаанбаатар хотын барилгын салбарын бизнес эрхлэгчидтэй болон Орхон, Сүхбаатар, Дорнод, Өмнөговь зэрэг аймгийн ХАҮТ-ын бизнес эрхлэгчдийг хамруулсан хэлэлцүүлэг
6. “Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2016-2030 он)” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг

ГАРГАСАН МЭДЭГДЭЛ, УРИАЛГА:

1. Тавантолгойг ажиллуулах тухай УИХ, ЗГ-т хандсан МҮХАҮТ-ын уриалга гаргасан. Мөн энэ хүрээнд Бизнес тусгаар ногоон гэрэл асаа уриан доор хэвлэлийн бага хурал хийсэн.
2. “Бизнес эрхлэгчдэд боломж олгож байж эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс гарна” мэдэгдэл гаргаж хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлд өгч олны сонорт хүргэсэн /2015.06.09/
3. “Бидэнд дэлхийн дэвжээ ойрхон байна”. /2015.07.03/
4. “Баялаг бүтээгчдээ нэг гараанаас гаргацгаая”. /2015.08.06/
5. Бизнес эрхлэгчдийн анхааралд: Эдийн засгийн эрх чөлөөгөө хангацгаая! /2015.11.02/
6. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах, хугацааг сунгах, “МЭДЭГДЭЛ” /2015.11.27/
7. “Ил тод болгох хөрөнгөө бүртгүүлж батлуулахад саадгүй боллоо” /2015.12.04/
8. Тавантолгойг ажиллуулах тухай УИХ, ЗГ-т хандсан МҮХАҮТ-ын уриалга гаргасан. Мөн энэ хүрээнд Бизнес тусгаар ногоон гэрэл асаа уриан доор хэвлэлийн бага хурал хийсэн. /2015.04.23/
9. “Бараа, ажил, үйлчилгээ борлуулагч хувь хүн, хуулийн этгээдүүдэд хүргэх уриалга” /2015.12.11/
10. “Улс орны эдийн засаг тогтвортой байдлыг нэхэж байна” мэдэгдэл /2016.01.21/

ТАНХИМЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛ

Танхимын дэргэд нийтдээ **32** зөвлөл үйл ажиллагаа явуулж байна. Зөвлөл хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор B2B networking уулзалтыг амжилттай зохион байгуулсан.

МҮХАҮТ-ын Удирдлагууд Бизнесийн салбаруудын төлөөлөлтэй уулзаж Бизнес эрхлэхтэй холбоотой учирч буй хүндрэл бэрхшээлүүд, Төр засаг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, бизнесийн хууль эрх зүйн орчинг сайжруулах, төрийн хүнд суртал авилга, хээл хахуулийг багасгах гээд бизнесийн орчинг сайжруулахтай

холбоотой асуудлуудаар санал бодлоо солилцохуулзалтыг зохион байгуулахаар Салбарчилсан уулзалтуудыг хийсэн. Үүнд:

- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл
- Барилга дэд бүтцийн зөвлөл
- Гаалийн зуучлагчдын үйл ажиллагаа эрхлэгчдийн зөвлөл
- Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зөвлөл
- ОХУ-тай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
- Захуудын зөвлөл

- Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын нэгдсэн зөвлөл
- Аялал жуулчлалын зөвлөл
- Итгэмжлэгдсэн лабораториудын зөвлөл
- Худалдаа тээврийг хөнгөвчдөх зөвлөл
- Сав баглаа боодлын зөвлөл
- Импортлогчпын зөвлөл
- Экспортлогчдын зөвлөл
- ШУ инновацийн зөвлөл
- Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлын зөвлөлүүдийн уулзалтуудыг зохион байгууллаа.

Зөвлөлийн хүрээнд хийсэн томоохон арга хэмжээнүүдээс дурдвал:

Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлын зөвлөл: МҮХАҮТанхим ба НДЕГазар хамтран «Ослын даатгалын тогтолцоо, Герман ба Монгол» олон улсын форумыг амжилттай зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд төрийн ба төрийн бус, мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллагын төлөөлөл, хувийн хэвшлийн захирал, менежер, аюулгүй ажиллагааны инженерүүдийг багтаасан **150** хүн оролцсон томоохон арга хэмжээг зохион байгуулсан. Уг олон улсын форумд ХБНГерман улсын Ослын даатгалын тогтолцооны байгууллагын ажилтан: доктор Gregor Kemper, Sven Timm, Edlyn Ho-eller нарын экспертүүд ирж, Германы ослын даатгалын тогтолцооны өнөөгийн байдал, ослоос урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөлтийн талаарх туршлагаа Монголын мэргэжил нэгтнүүдтэйгээ хуваалцсан байна

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл: Гадаад худалдааны санхүүжилтийн боломжууд» сэдэвт семинарыг Голомт банктэй хамтран зохион байгуулсан. Танхимын зүгээс «Гадаад худалдааны баримт бичгүүд», «Бизнесийн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх нь давагдашгүй хүнд

нөхцөл байдал» илтгэлүүдийг тавьж оролцогчдод танхимын талаарх сонин сэтгүүлийг тараалаа. Семинарт нийт **200** гаруй бизнес эрхлэгчид хамрагдлаа.

Сэргээгдэх эрчим хүчний зөвлөл: Дэлхийн салхины холбоо, Монголын салхины ассоциаци, Сэргээгдэх эрчим хүчний зөвлөл хамтран Монгол улсад Салхины эрчим хүчний олон улсын бага хурал зохион байгуулж Сэргээгдэх эрчим хүчний хуулийг шинэчлэх талаар, сэргээгдэх эрчим хүчний бодлогын талаар хэлэлцсэн, Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг IRE-NA-гаас зохион байгуулсан Монгол улсын сэргээгдэх эрчим хүчний аж ахуйн нэгжүүдэд зориулсан “Project navigator” төслийн сургалт, 60 аж ахуйн нэгжийг хамруулсан.

Эрүүл мэндийн зөвлөл: Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран “Эхэд ээлтэй ажлын байрыг дэмжицгээе” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулахад Танхимын дэргэдэх Компанийн Нийгмийн хариуцлагын зөвлөл гишүүн байгууллагуудаа оролцуулан хамтран ажилласан.

Аялал жуулчлалын зөвлөл: Зүүн хойд азийн Олон улсын аялал жуулчлалын 11-р форумыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим түүний дэргэдэх Аялал жуулчлалыг хөгжүүлэх зөвлөл, Монголын аялал жуулчлалын холбоо, Нью Жуулчин Турс ХХК хамтран зохион байгуулж буй уг форумд БНХАУ-аас 20, Японоос 40, БНСУ-аас 50, ОХУ-аас 10, Монголоос **120** орчим төлөөлөгч оролцлоо.

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зөвлөл: Зөвлөлийн гишүүдээр дамжуулан 6 дүүргийн **300** гаруй бичил бизнес эрхлэгчдээс хууль эрхзүйн орчны судалгааг авлаа.

ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

2015 онд Танхимын 55 жилийн ойг тохиолдож байгаатай холбогдуулан энэ онд нийт **40** орчим томоохон арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор **1200** компани, **4000** бизнес эрхлэгчид, хувь хүмүүсийг хамруулсан байна. Томоохон арга хэмжээнээс дурдвал:

2014 оны шилдэг 100 аж ахуйн нэгж



Монгол улсын Засгийн газар, МҮХАҮТ хамтран 2001 оноос жил бүр уламжлал болгон Монгол улсын нийгэм, эдийн

засаг, бизнесийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж буй манай улсын шилдэг /ТОП/ аж ахуйн нэгжүүдийг шалгаруулж ирсэн уг арга хэмжээг 14 дэх жилдээ зохион байгууллаа. “ТОП-100”-г өргөмжлөх ёслолын арга хэмжээ Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборт болсон бөгөөд арга хэмжээнд Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Аж үйлдвэрийн Сайд Д.Эрдэнэбат, Сангийн Сайд Ж.Эрдэнэбат, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын удирдлагууд, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг төрийн холбогдох байгууллагуудын төлөөлөл болон МҮХАҮТ-ын удирдлагууд оролцон аж ахуйн нэгжүүдэд баяр хүргэж, шагнал гардууллаа.

55 жилийн ой угтсан арга хэмжээнүүд:

Бизнес лиг: 55 жилийн ойн хүрээнд гишүүн байгууллагуудын дунд “BUSINESS LEAGUE” шилжин явах цомын төлөөх Сагсан бөмбөгийн тэмцээнийг МҮХАҮТ-аас зохион байгуулж, Бизнесийн салбарт ажиллаж байгаа нөхдийнхөө чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, эрүүл оршихуйг төлөвшүүлэх, спортын талбарт шударгаар өрсөлдөх, харилцан ойлголцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс зохион байгуулсан. Тус тэмцээнд **20** байгууллагын **300** гаруй дасгалжуулагч, баг тамирчид оролцсон. 1-р байрт Мобиком Корпораци ХХК, 2-р байрт Хас банк, 3-р байрт Голомт банк, шилдэг тоглогчоор Мобиком корпорацийн тамирчин Бат-эрдэнэ тус тус шалгарсан.



Бизнес парад: 2000 оноос эхлэн уламжлал болон зохион байгуулагдаж байгаа нэрхүнд бүхий энэхүү арга хэмжээг

“Бизнест ногоон гэрэл асаацгаая!” уриан дор Бизнес эрхлэгчдийн парад буюу “Бизнес Фестиваль 2015” арга хэмжээг 10 дахь удаагаа зохион байгуулж 2015 оны 6 дугаар сарын 21-ний өдөр 38 гишүүн байгууллага оролцсон.



Нээлттэй өдөрлөг: МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн гишүүдэд танхимаас бизнес эрхлэгчдэд үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ болон нэг цэгийн үйлчилгээ, эрхлэн гаргаж буй ном товхимол, гарын авлагыг сурталчилан

таниулах зорилгоор “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний бага хурал: 55 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд уламжлал ёсоор 3 дахь жилдээ ШУТИС-БУХС, МЛХ-той хамтран “Нийлүүлэлтийн хэлхээний менежментийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийн уралдааныг зохион байгуулж багш, судлаачаас 3, оюутан 3-ыг тус тус шалгаруулж бүтээлийн эмхэтгэлийг хэвлүүлсэн.

55 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээ: 7-р сарын 3-ны өдөр МҮХАҮТ 55 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан. Ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, УИХ-ын нэр бүхий гишүүд, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав болон гадаад, дотоодын хамтран ажилладаг байгууллагын төлөөлөл зочид олноороо оролцов. 500 орчим гишүүд арга хэмжээнд оролцсон.



**Хөдөлмөрийн гавъяаны
улаан тугийн одон хүлээж
авах ёслолын ажиллагаа:**



МҮХАҮТ-ын хувийн хэвшлийн салбарторуулсанхувьнэмрийг өндрөөр үнэлэн Монгол улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 7-р сарын 8-ны өдрийн 128 дугаар зарлигаар “ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-гоор шагнасныг гардуулах ёслолын ажиллагаа 2015 оны 11-р сарын 16-ны өдөр МҮХАҮТ-ын Их танхимд боллоо. Шагналыг Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газрын дарга П.Цагаан гардуулж өгсөн.

Үндэсний чанарын 7 хоног чуулган, үзэсгэлэн, хэлэлцүүлэг, шагнал гардуулах ёслолын ажиллагаа:



Дэлхийн Чанарын 7 хоногийг тохиолдуулан Европын холбооны “Стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох нь” төслийн санхүүжилтээр Стандартчилал хэмжил зүйн газартай хамтран Үндэсний чанарын чуулганыг 11-р сарын 25-ны өдөр нийт **300** гаруй бизнес эрхлэгчдийг хамруулан зохион

байгуулсан. Энэхүү чуулганы үеэр Чанарын тогтолцооны талаар форум, Монгол улсын үндэсний чанарын бодлого ба хөтөлбөр хэлэлцүүлэг, итгэмжлэл, баталгаажуулалтын байгууллага, лабораториудын үзэсгэлэн, Үндэсний чанарын шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулсан.

B2B уулзалт:

МҮХАҮТ-ын гишүүд хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 4 сараас эхлэн сар бүр тодорхой сэдвээр B2B уулзалтыг шинээр зохион байгуулж эхэлсэн бөгөөд нийт **5** удаагийн уулзалтанд давхардсан тоогоор **450** орчим бизнес эрхлэгчид, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, эрдэмтэд хамрагдсан.

- 4 сард “Японы EPA-ын хэлэлцээр”
- 5 сард “Young entrepreneurs”
- 6 сард “Худалдаа хөнгөвчлөх асуудлууд”
- 9 сард “Бизнесийн салбар зөвлөлүүдийн уялдаа холбоо”
- 11 сард “Бизнес эрхлэгч Та эрсдэлд бэлэн үү?”



Бусад томоохон арга хэмжээнүүдээс:

- ОХУ-ын Бурятмяспром компани Монголын мах экспортлогч **30** гаруй компанитай оролцсон.
- АҮЯ-ны сайд Д.Эрдэнэбат ба Бурядын танхимын дарга Зураев болон Бурятмяспром ХХК-ны удирдлагуудтай уулзалт хийсэн.
- АҮЯ-тай хамтарсан Евразийн комиссын гишүүдтэй **25** байгууллагын **40** гаруй бизнес эрхлэгчид уулзсан.
- УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, АҮЯ-тай хамтарсан ЖДҮ эрхлэгчдийн үндэсний чуулганаар нийслэл болон орон нутгийн **500** гаруй бизнес эрхлэгчид оролцсон.
- ЖДҮ эрхлэгчдэд татварын хууль тогтоомжийг даган мөрдөхөд учирч буй хүндрэл бэрхшээлийг багасгахад чиглэсэн стратегийг боловсруулах зорилготой, Олон улсын валютын сантай хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэг уулзалт хийсэн.
- СЗХ, ЖАЙКА-тай хамтран IPO-dual listing өндөр хэмжээний семинарт танхимын тэргүүлэгч гишүүд болон ТОП-100-аар шалгарсан байгууллагууд болон үнэт цаас, дилерийн компаниудын төлөөлөл зэрэг **100** гаруй хүнийг хамруулсан.
- АҮЯ-тай хамтарсан “Японы зах зээлд хэн гарах вэ” уулзалтанд **200** гаруй бизнес эрхлэгчид оролцсон.
- “Монгол, Японы хөдөө аж ахуйн салбарын анхдугаар форум»-д **60** орчим бизнес эрхлэгчийг урин оролцуулсан.
- Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтарсан, Чингисийн талбайд зохион байгуулсан “Хуульчид зөвлөж байна” нээлттэй өдөрлөгийн үеэр Арбитр, БМЭЗ төвийн үйл ажиллагааг сурталчлан гарын авлага ном, гэрээний загвараар үйлчилж

200 гаруй иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөөг өгсөн.

- “Алтанбулаг-2015, Эдийн засгийн чуулга уулзалт» - Чуулга уулзалтад АҮЯ, ГЕГ, ТЕГ, МХЕГ, УБЕГ, Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн алба болон бизнес эрхлэгчид нийт **120** гаруй хүн оролцов.



- АҮЯ-тай хамтран зохион байгуулсан “Санхүүгийн түрээсийн үйлчилгээ - 2015” арга хэмжээнд нийт 16 тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, нийлүүлэгч, зуучлагч компаниуд, 4 банк санхүүгийн байгууллага оролцож өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан. Тайвань улсын “Turnkey” танилцуулга, Хятад улсын Хөнгөн үйлдвэрийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн нийгэмлэгийн мэдээлэл хийгдсэн ба тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдах сонирхолтой **300** гаруй иргэн, аж ахуйн нэгжүүд ирж мэдээлэл авсан.
- Монголын энтрепренёруудын нэгдсэн чуулган 2015-ыг АҮЯ-тай хамтран зохион байгуулсан.

- Телемост видео хэвлэлийн бага хуралд /ОХУ-ын Томскийн ХАҮТанхим / ОХУ-ын бизнес эрхлэгчид **30** орчим, Монголын бизнес эрхлэгчид **30** орчим хүмүүс хамрагдсан.
- НӨАТ суутган төлөгч нарт зориулан ebarimt.mn цахим хуудсанд НӨАТ-ын цахим падаан үүсгэх, НӨАТ-ын цахим тайлан гаргах болон анхаарах асуудлууд сэдвээр сургалтыг ГТЕГ-тай хамтран зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор **891** орчим аж ахуй нэгж, **1500** орчим хүн хамрагдсан.
- “Торгоны зам 2016” - Монгол орны эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа Олон улсын байгууллагууд, хоёр талын техникийн туслалцааны болон бусад гадаадын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүд, Дипломат төлөөлөгчийн газрууд, гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын иргэдийг онцлон шалгаруулах, тэднийг урамшуулан дэмжих, нийтэд таниулах зорилгоор “Silk Road” буюу “Торгоны зам” шагнал гардуулах ёслолын арга хэмжээг хоёр жил тутамд нэг удаа зохион байгуулдаг уламжлалтай билээ. Энэ жилийн шагнал гардуулах ёслолд **42** албан байгууллагын **78** хүн оролцсон.
- Ноос ноолуурын зөвлөл, Отгонтэнгэр Их Сургууль, ШХА-ын Ногоон Алт төслийн Маркетингийн бүрэлдэхүүн хэсэг, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран “Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүнийг ОУ-ын зах зээлд гаргах боломж, арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж **30** аж ахуй нэгж оролцон 18 илтгэл тавигдан 3 байр шалгаруулсан.
- Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж буй шилдэг аж ахуй нэгж, байгууллагууд, бизнес эрхлэгчдийг шалгаруулан өргөмжилдөг “Entrepreneur-2015” Mercury цом гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулж **200** гаруй аж ахуй нэгж оролцож, салбар салбарын онцлох **38** аж ахуй нэгж, MERCURY цомын эзнээр оны онцлох 10 аж ахуй нэгж шалгаруулсан байна ба энэхүү арга хэмжээнд нийт **200** гаруй бизнесийн төлөөлөл оролцсон.
- Гарааны бизнесийг дэмжих “Boosting Mongolia” уулзалтыг Монгол Улсад гарааны бизнес, энтрепренер экосистемийг бүрдүүлэх чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлдэг Startup Mongolia ТББ-тай хамтран зохион байгуулж **20** гарааны бизнес үзэсгэлэн гаргаж, **250** оролцогч, **10** илтгэгч оролцсон.
- Монгол улсын Хөдөлмөрийн яамны харъяа Хөдөлмөрийн Эрүүл Мэнд Судлалын Төвтэй хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, олон нийтийн хөдөлмөрийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор салбарын **30** гаруй төлөөллийн бүрэлдэхүүнтэй сургалт, уулзалт зохион байгуулсан.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

2015 оны 12 дугаар сард ХонгКонгод “Торгоны Зам олон улсын хөрөнгө оруулалтын чуулган”-ы үеэр БНХАУ-ын дарга Си Жин Пины XXI дугаар зууны Ази, Африк, Ойрхи Дорнод, Европыг холбосон Торгоны зам байгуулах санаачилгаар 4 тэрбум хүн амтай Торгоны зам дагуух 60 гаруй орнуудын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх дэлхийн бусад орнуудтай холбох Торгоны Зам Олон Улсын Худалдааны Танхимыг 40 гаруй орны санаачилгаар байгуулсан. Үйл ажиллагааны дүрмээ баталж зохион байгуулалтын асуудал хэлэлцэж удирдах дээд байгууллагаа сонгосон бөгөөд Дэд Ерөнхийлөгчөөр МҮХАҮТ-ын дарга М.Оюунчимэг сонгогдсон нь манай танхимын олон улс дахь нэр хүндийг өсгөн, дээрх орнуудын бизнес эрхлэгчидтэй худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой явдал боллоо.

Дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:

2015 онд 12 байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна.

1. Чингэлтэй дүүрэг /2015.03.05/
2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /2015.03.18/
3. Монгол улсын шинжлэх ухааны академи /2015.04.14/
4. Нийслэлийн жижиг дунд үйлдвэрийн газар /2015.04.14/
5. Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо /2015.04.14/
6. ШУТИС, МУИС /2015.05.18/
7. Чингис Лэнд Девелопмент Групп - Шинэ хөгжлийн зам ХХК, Монголын авто замчдын холбоо /2015.05.27/
8. Зээлийн батлан даалтын сан /2015.06.10/
9. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар /2015.06.17/
10. Шингэрүүлсэн хийн аж ахуй эрхлэгчдийн холбоо /2015.08.31/
11. Санхүү эдийн засгийн дээд сургууль /2015.12.17/
12. Нийгмийн халамж, үйлчилгээний газар /2016.01.26/

Мөн 11 байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичгийг шинэчлэн зурах асуудлаар албан тоот бичиж, төслийн хамт хүргүүлсэн.

- | | |
|---|--------------------------|
| 1. Хүнс, хөдөө аж ахуйн яам, | 7. Хан-уул дүүрэг |
| 2. Аж үйлдвэрийн яам, | 8. Сонгинохайрхан дүүрэг |
| 3. Хөдөлмөрийн яам, | 9. Баянзүрх дүүрэг |
| 4. Барилга хот байгуулалтын яам | 10. Сүхбаатар дүүрэг |
| 5. Зам тээврийн яам | 11. Баянгол дүүрэг |
| 6. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар | |

Гадаад улс орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:

5 байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна.

1. ОХУ-ын Уралын худалдаа аж үйлдвэрийн танхим /2015.04.04/
2. НҮБ-ийн Хүүхдийн сан /2015.05.29/
3. Швейцарь-Азийн худалдааны танхим /2015.06.03/
4. Мянмар улсын худалдаа аж үйлдвэрийн танхимуудын холбоо /2015.06.29/
5. Унгар улсын худалдааны төв /2016.01.25/

Мөн 7 байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичгийг зурах, хамтран ажиллахаар санал солилцож, албан тоот бичиж хүргүүлсэн.

- | | |
|--|---|
| 1. Францын ХАҮТ | 5. Виржиния Азия Худалдааны танхим |
| 2. Италийн Худалдааг дэмжих агентлаг | 6. Бангладешийн Экспортыг дэмжих зөвлөл болон Энэтхэгийн Аж Үйлдэрүүдийн холбоо |
| 3. Данийн Аж Үйлдвэрүүдийн холбоо | 7. Туркменистаны ХАҮТанхим |
| 4. Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны холбоо | |

БИЗНЕС УУЛЗАЛТ

2015 онд өндөр хэмжээний айлчлал болон хоёр талын бизнесийн төлөөлөлтэй монголын бизнес эрхлэгчдийг холбох **13** бизнес уулзалтанд **252** аж ахуй нэгжийн **370** хүн оролцсон. Үүнд:

1. Турк улсын Ерөнхий сайдын Монгол улсад хийх айлчлалтай холбогдуулан Монгол Туркийн бизнес эрхлэгчдийн уулзалт
2. Энэтхэгийн Ерөнхий сайдын Монгол улсад хийх айлчлалтай холбогдуулан Энэтхэгийн аж үйлдвэрийн танхимтай хамтран Монгол Энэтхэгийн эм, эмнэлэгийн салбарын бизнес эрхлэгчдийн уулзалт
3. Австрийн эдийн засгийн танхимтай хамтран Монгол Австрийн бизнес форум
4. Монгол, Японы Засгийн газар, хувийн хэвшлийн худалдаа, хөрөнгө оруулалтын VII зөвлөлдөх уулзалт
5. Тайваний Тайпей хотноо Монгол Тайваний 14 дэх удаагийн бизнес уулзалт
6. Монгол - Чехийн бизнес уулзалт
7. Япон улсын Токио хотноо Япон Монголын төр хувийн хэвшлийн зөвлөлдөх 7 дугаар уулзалт
8. Монгол - Туркменистаны бизнес уулзалт БНГУ-ын Ерөнхийлөгч Иоахим Гаукийн төрийн айлчлалын хүрээнд германы төлөөлөгчидтэй хийсэн уулзалт
9. "Орос-Монгол-бизнесийн шинэ хөгжил" бизнес форум
10. Хятад-Казахстаны "Хоргос" эдийн засгийн онцгой бүсийн талаар танилцуулга уулзалт
11. Томск хотын ХАҮТ-тай хамтран хүнс,мал, хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн дугуй ширээний уулзалт
12. Монгол Казахстан хоёр улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн уулзалт

Монгол - Унгарын бизнес форум:

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн урилгаар Бүгд Найрамдах Унгар Улсын Ерөнхий сайд Виктор Орбан / Victor Orban/ Монгол Улсад айлчиллаа. Унгарын уулзалт өдөрлөгийг МҮХАҮТ-ын Их танхимд хоёр улсын бизнес эрхлэгчдийн дугуй ширээний уулзалт, Унгарын аж ахуйн нэгж, байгууллагуудын үзэсгэлэн худалдаа, ганцаарчилсан уулзалтууд зохион байгуулагдсан. Унгарын талаас **43** компаний **63** төлөөлөгч Монголын талаас **174** төлөөлөгч оролцов.



ТАНХИМЫН УДИРДЛАГУУДЫН УУЛЗАЛТ

Танхимын удирдлагуудын зүгээс өнгөрсөн онд бизнес эрхлэгчидтэй санал солилцох, бодол санааг нь сонсох, зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор нийт 30 орчим хүмүүстэй ганцаарчилан уулзсан бөгөөд төрийн 8 байгууллага, төрийн бус 10 байгууллага, Монголд суугаа гадны орны элчин сайд, Олон улсын байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч бүхий 25 хүмүүстэй уулзсан байна. Тухайлбал:

1. Олон улсын валютын сангийн шинэ суурин төлөөлөгч
2. Казакстан Улсаас МУ-д суугаа Элчин сайд
3. Польшийн Хөрөнгө оруулалтын агентлагийн төлөөлөгчид
4. Бээжин дэх Францын худалдаа хөрөнгө оруулалтын газрын төлөөлөгчид
5. ЖАЙКА, Монгол-Японы төвийн төлөөлөгчид
6. Францын ХАҮТ
7. Michael Walther, Bauhaus university
8. ОХУ-ын ЭСЯ-ны төлөөлөгч
9. Бээжин хот дахь Бүгд Найрамдах Бангладеш Улсын Элчин сайд
10. Унгар улсын худалдааны төлөөлөгчийн газар
11. Герман-Монголын Бизнес эрхлэгчдийн холбоо
12. Гадаад хэргийн яамны сайд
13. Мянганы сорилтын сан
14. Туркменстан ХАҮТ
15. Куба улсын элчин сайд
16. Польш улсын элчин сайд
17. Татварын ерөнхий газар
18. Монголын Маркетинг Менежментийн хүрээлэн
19. Турк дэхь Монголын өргөмжит консул
20. АНУ-ын худалдааны яам - Монгол, Хятадыг хариуцсан захирал
21. Германы элчин сайд
22. Азийн сан
23. Узбекистан элчин сайд
24. SEQUA Германы төсөл
25. Аж үйлдвэрийн яам
26. Хөрөнгө оруулалтын газар
27. Азийн хөгжлийн банк
28. Цементийн бизнес эрхлэгчдийн холбоо ТББ
29. Нийгмийн Халамж Үйлчилгээний Ерөнхий Газар
30. Улаанбаатар банк
31. Монголын Үндэсний Маркетингийн холбоо
32. Баян Хан Трейд ХХК
33. Барилгын үндэсний ассоциаци
34. Шинэ хөдөлгүүр ХХК
35. Уул уурхайн танхим
36. Урлаг маркет ХХК
37. JV CONSULT
38. Тэнгэр даатгал
39. 100 айл худалдааны төв
40. Reserve Consulting ХХК
41. МҮОНТ Амжилтын түлхүүр ТББ
42. Nomin Consulting Development
43. Нефтийн үндэсний ассоциаци
44. LCN LLC (Эл Си Эи ХХК)
45. ӨВМТХ ХХК
46. Престиж Групп
47. Зүүмэл даавуу урлал ХХК
48. Монгол – Унгарын найрамдлын нийгэмлэг
49. НҮБ Хөгжлийн хөтөлбөр
50. IT ZONE, Biznetwork ХХК



ҮЗЭСГЭЛЭН

ГАДААД

2015 онд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, гадаад орнууд руу зах зээлээ өргөтгөх, эдийн засгийн хямралыг даван гарах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор БНХАУ, ОХУ, ХБНГУ, БНСУ, БНАСАУ, Вьетнам зэрэг 6 улсын 10 хотуудад 12 удаагийн үзэсгэлэнг зохион байгуулсан байна. Томоохон үзэсгэлэнгээс дурдвал:

Монгол - Хятадын анхдугаар ЭКСПО 2015

Үндэсний үйлдвэрлэгчдийг сурталчилсан гадна хэсэгт байршуулсан талбайд ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч **71**, арьс ширэн эдлэл **59**, үндэсний хувцас эдлэл **37**, алт мөнгө үнэт эдлэл **20**, гоо сайхан **4**, үндэсний гэр гэрийн тавилга **2**, nano технологи **1**, хүнсний **36** аж ахуйн нэгж тус тус оролцлоо. Нийт **230** компаний **400** хүн хамруулж **7** сая орчим юаны борлуулалтыг хийж амжилттай оролцлоо.

Монгол Улсыг таниулан сурталчлах үзэсгэлэнд нийт Монгол Улс, нийслэл Улаанбаатар хот, 16 аймгуудын / Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Ховд, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Булган, Дорноговь / нийт 18 стэндийг Орон нутгийн салбар танхимууд хариуцан ажиллуулсан.



Бусад:

1. ӨМӨЗО-ны нийслэл Хөх хотноо “Азийн цагаан сар” ОУ-ын үзэсгэлэн худалдаа
2. Вьетнам улсын Хо Ши Мин хотноо “FOOD-EXPO VIETNAM 2015” хүнсний салбарын хамгийн том үзэсгэлэн яармаг
3. БНАСАУ-ын Пхеньян хотноо зохион байгуулагдсан хаврын яармаг
4. БНХАУ-ын Эрээн хотноо “Монголын бараа бүтээгдэхүүн”-ий үзэсгэлэн
5. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотноо Танхимуудын уулзалт, үзэсгэлэн
6. Эрээн хотын Ардын Засгийн газартай хамтран “Хятад-Монгол-Орос улсын эдийн засаг, худалдаа хамтын ажиллагааны Эрээн хотын чуулга уулзалт, үзэсгэлэн”
7. БНХАУ-ын Жилин мужийн Чаньчунь хотноо “Зүүн Хойд Азийн худалдаа хөрөнгө оруулалтын чуулга уулзалт, үзэсгэлэн”
8. БНХАУ-ын Шаньси мужийн Сиань хотноо “Шанхайн хамтын ажиллагааны орнуудын форум-үзэсгэлэн”
9. ОХУ-ын Эрхүү хотноо Агро үйлдвэрийн үзэсгэлэнд
10. БНСУ-ын Геонгсаннам мужийн Жинжү хотноо “Хүнс, ХАА-н бүтээгдэхүүний үзэсгэлэн”
11. БНГУ-ын Берлин хотноо Берлин базаар үзэсгэлэн
12. Эрхүү хотноо Шинэ жилийн үзэсгэлэн

ДОТООД

Дотооддоо бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг таниулан сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор том жижиг **20** гаруй үзэсгэлэнг Танхимганцаарааболонбусадтөрийнболонтөрийнбусбайгууллагуудтай хамтран зохион байгуулах, тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ үзүүллээ. Зохион байгуулсан **9** үзэсгэлэнд **434** албан байгууллага, аж ахуй нэгжүүд оролцсон байна.

ЖДҮ-ийн үзэсгэлэн

ЖДҮ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи 2015 Олон улсын үзэсгэлэнг 19 дэх жилдээ МҮХАҮТ үүсгэн байгуулагдсаны 55 жилийн ойн хүрээнд зориулан зохион байгууллаа. Энэ удаагийн үзэсгэлэнд гадаадаас БНХАУ-ӨМӨЗО-оос 24 компани, байгууллага, Польш, Чех, БНАСАУ тус тус оролцуулж, мөн дотоодын нийт 55 гаруй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид, хувиараа бизнес эрхлэгчдийг хамрууллаа.



“Улаанбаатар түншлэл 2015” үзэсгэлэн

Монгол Улсад үзэсгэлэнгийн салбар үүсч хөгжсөний 40 жилийн ойд зориулсан “Улаанбаатар түншлэл-2015” намрын Олон Улсын үзэсгэлэн 9-р сарын 10-14-ний өдрүүдэд “Мишээл экспо” төвд амжилттай зохион байгуулсан. Энэ удаагийн үзэсгэлэнд Монголын аж ахуйн нэгжүүдээс гадна БНАСАУ, Тайвань, Непал, ОХУ, Польш, Унгар зэрэг улс орноос нийт 30 гаруй аж ахуйн нэгж ирж Монголын хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилахаар оролцож байна.



Бусад:

1. Coal Mongolia - 2015 Олон Улсын нүүрсний салбарын хөрөнгө оруулагчдын чуулганы үеэр зохион байгуулсан үзэсгэлэн
2. License Academy - Японы Их Сургуулийн Сонины Газар Японы Боловсрол, ЖЕТРО төлөөлөгчийн газрын сурталчилгааны үзэсгэлэн
3. “Монголын Оюутны холбоотой зохион байгуулсан Монголын Боловсрол-2015”
4. Төрийн ордонд зохион байгуулагдсан ЖДҮ-ийн Үндэсний зөвлөгөөнд зориулсан үзэсгэлэн
5. МҮХАҮТ, Аж Үйлдвэрийн Яам хамтран зохион байгуулсан Санхүүгийн түрээсийн үйлчилгээ -2015 үзэсгэлэн
6. МҮХАҮТ, Аж Үйлдвэрийн Яам, НЗДТГ, ХХААЯ хамтран зохион байгуулсан “Монголд үйлдвэрлэв 2016” үзэсгэлэн
7. Итгэмжлэгдсэн лаборатори, баталгаажуулалтын байгууллагуудын Чанарын үзэсгэлэн

СУРГАЛТ

Танхимын дэргэд **11** төрлийн сургалт, **19** удаагийн давтамжтайгаар явагдаж нийт **569** хүн хамрагдав. Шүхэр тогтолцооны хүрээнд хамтран ажилладаг дараах байгууллагуудтай хамтарсан чадамжийн гэрчилгээг олгосон. Үүнд: “Туул” сургалтын төвтэй хамтарч **12** хүнд, “Ховор угалз” сургалтын төвтэй хамтарч **5** хүнд, “Нью загал” сургалтын төвтэй хамтарч **83** хүнд тус тус чадамжийн гэрчилгээг олгосон байна.

1. Гадаад Худалдааны Академийн Гадаад худалдааны менежерийн Даваа, Пүрэв, Бямба гарагийн 1 жилийн сургалт - 87 төгсөгч төгссөн.
2. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалт- нийт **46** хүн
3. Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт 6 удаа, **103** оролцогч хамрагдсан
4. Компаний захирлуудад зориулсан CEO High level course- 2 удаа, нийт **39** хүн
5. Компьютерийн сүлжээний мэргэжил-тэн бэлтгэх сургалт- 2 удаа, нийт **31** хүн
6. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалт - 2 анги, **46** хүн
7. “Үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэх чадвар” 1 өдрийн сургалт- **57** хүн
8. “Гадаад худалдааны гэрээ байгуулахад анхаарах асуудлууд, Инкотермс 2010, гадаад худалдааны төлбөр тооцоо, санхүүжилт” сэдвээр 2 өдрийн сургалтанд **44** компаний **68** хүн.
9. Хүнсний салбарт экспорт, импортын үйл ажиллагаа эрхлэгч ажахуй нэгжүүд болон гаалийн бүртгэгдсэн нарт зориулсан “ БТКУС-ийг хүнсний салбарт ашиглах нь” сэдэвт нэг өдрийн сургалтанд **22** хүн
10. “Гаалийн горимын эдийн засгийн ач холбогдол” сэдэвт нэг өдрийн сургалтыг гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүд, экспорт импортын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдийн гаалийн асуудал хариуцсан **50** гаруй ажилтнуудад зориулан зохион байгуулсан.
11. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан тендерийн санал боловсруулах сургалт- 2 удаа нийт **20** хүн хамрагдсан.

Танхимын ажилчдын чадавхыг сайжруулахад зориулан зохион байгуулсан сургалт:



Танхимын ажилчдыг чадавхжуулах, чадварлаг багаар гишүүн байгууллага бизнес эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлэх зорилгоор дараах **11** төрлийн сургалтуудыг нийт **12** газрын дарга нар, ажилтнуудад зориулан зохион байгуулсан.

1. Стратегийн удирдлага - Эрдэм шинжилгээний ухааны профессор Л.Оюунцэцэг
2. Эрсдлийн удирдлага-Голомт банкны ерөнхийлөгч Ө.Ганзориг
3. Загварчлах сэтгэлгээ-Tech starts олон улсын байгууллагын зүүн өмнөд азийн салбарын захирал Д.Бат-Октябрь
4. Байгууллагын соёл, зан төлөв-Компанийн засаглалын шинжилгээний хүрээлэнгийн захирал Н. Цогжавхлан
5. Хүний нөөцийн сургалт-Оюуны ундраа группын Хүний нөөцийн захирал
6. Багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх сургалт
7. Менежмент ба маркетинг-Удирдлагын академийн багш Ц.Өнөржаргал
8. Цаг ашиглалтыг сайжруулах сургалт-ОХУ-ын тасралтгүй боловсролыг дэмжих нийгэмлэг
9. Архив, албан бичиг хөтлөлт
10. Хүний нөөцийн системийн сургалт- Biznetwork ХХК
11. Байгууллагын маркетинг, брэндийг хэрхэн-Нидерланд эксперт Fred de Boer

СУДАЛГАА

Дараах бие даасан тоймуудыг шинэчлэн бэлтгэсэн.

1. Үхрийн ширний зах зээл
2. Үхрийн хөлдүү махны зах зээл
3. Төмсний зах зээл
4. Жамц давсны зах зээлийн тойм
5. Чацарганы зах зээл
6. Зөгийн балны зах зээл
7. Өлөн гэдэсний зах зээл
8. Ноолуурын зах зээл
9. Алтны зах зээл
10. Нүүрсний зах зээл
11. Зэсийн зах зээлийн тойм
12. “Монгол улсын гадаад худалдааны шинжилгээ, дүгнэлт” тойм

Судалгаа:

1. Татварын ерөнхий хуулийн төсөл болон одоо үйлчилж байгаа татварын ерөнхий хуулийн харьцуулсан судалгаа
2. Бизнесийн итгэлийн индекс 2015 судалгаа
3. Market Access Map, Trade Map—ийг ашиглан Монгол-БНСУ-ын худалдааны статистик, зах зээлийн тойм
4. Дэлхийн улс орнуудын нийт бараа бүтээгдэхүүний экспортын үнийн мэдээлэл
5. Дэлхийн улс орнуудын импортын үнийн мэдээлэл 02 бүлэгт хамаарах мах, дайвар махны статистик үзүүлэлт
6. АХБ-тай хамтран КАРЕК-ын 4Б коридороор тээвэр хийхэд гарч байгаа хүндрэл, цаг хугацаа, зардлыг тодорхойлох судалгаа, UNESCAP-аас гаргасан TCD аргачлалаар
7. “Монголын хил орчмын худалдаа-2015” судалгаа гаргасан. Судалгаанд Монгол улсын хилийн худалдаа-2015, МУ-ын Гадаад худалдаа, хилийн боомтуудаар, импорт, экспортын харьцуулт, болон чөлөөт бүсээр цаашид хэрэгжүүлэх боломжуудыг гаргаж, судалгаанд тусгасан.
8. 2014-2015 оны Монгол улсын хил дамнанас худалдааны үзүүлэлтүүдийн судалгаа
9. “Ургамлын тос”-ны зах зээлийн тойм судалгаа
10. Улаан буудайн дэлхийн зах зээлийн судалгаа
11. Дэлхийн гол хүнсний үнэ цаашид ямар байх вэ? Прогноз
12. Өргөн хэрэглээний барааны үнийн судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар валютын ханшны өөрчлөлтөөр үнийн дүнг харьцуулсан судалгаа
13. Далайд гарцгүй орнуудын хилийн худалдааны мэдээлэл солилцоог сайжруулах, цаасгүй худалдааг хөгжүүлэх, ЦНЦ-ны системийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ESCAP-тай хамтран ICT gap for Mongolia судалгаа
14. Бизнесийн итгэлийн индекс-2015
15. Хүнд суртлын индекс-2015

ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ

№	Үйлчилгээ	Үзүүлэлт
1	Гарал үүслийн гэрчилгээ	Монгол улсын экспортын барааны гарал үүслийг тодорхойлон 8500 ширхэг гарал үүслийн гэрчилгээ олгосон.
2	Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт эрхийн хамгаалалт, барааны тэмдэгтийн үйлчилгээ	Нийт 17 шинэ бүтээл, 2 бүтээгдэхүүний загварт эрхийн хамгаалалт хийлгэх үйлчилгээ үзүүлсэн. Нийтдээ энэ жилд 169 барааны тэмдэгтийн үйлчилгээ үзүүлсэн.
3	Арбитрын хэрэг	Энэ жилийн байдлаар 41 хэрэгт арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж, 56 нэхэмжлэл шинээр хүлээн авч 43 хэрэг хянан шийдвэрлэж өмнө нь ажиллагаа явагдаж байсан хэрэгтэйгээ нийтдээ 46 хэрэг дээр ажиллагаа явагдаж байна.
4	Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв	БМЭЗТ-өөр 53 хүсэлт хүлээн авч 16 эвлэрлийн гэрээ байгуулж 11 хүсэлтийг буцаасан, 17 маргаан эвлэрэл амжилтгүй болж, 6 маргааныг шүүхэд шилжүүлсэн.
5	Хууль, бизнесийн эрх зүйн зөвлөгөө	Танхимын гишүүн болон гишүүн бус 350 гаруй байгууллага иргэдэд бизнесийн эрх зүй, арбитр, эвлэрүүлэн зуучлал, давагдашгүй хүчин зүйлийн чиглэлээр эрх зүйн зөвлөгөөг өгсөн.
6	Давагдашгүй хүчин зүйл болон Хүнд нөхцөл байдлын гэрчилгээ	Ам долларын ханшийн өсөлт, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болж Давагдашгүй хүчин зүйл болон Хүнд нөхцөл байдлын гэрчилгээ авах 33 хүсэлт хүлээн авч судалгаа шинжилгээ явуулсанаас 3 хүсэлтийг нь буцааж, 4 хүсэлтэд тодохойлолт гаргаж өгч, 26 гэрчилгээ олголоо.
7	Зураасан код	Зураасан код олгох, гишүүний татвар хураамж авах зэрэг өдөр тутмын байнгын үйл ажиллагааг ханган ажилласан ба нийт 310 байгууллага шинээр элссэнээс 16 нь салбар танхимаас GS1 нийгэмлэгийн гишүүнээр элсэв. Мөн 80 гаруй байгууллага, хувь хүнд давтан код нийтдээ 1310 гаруй төрлийн бараа, бүтээгдэхүүнд стандарт зураасан код олгож зөвлөгөө өгсөн.
8	АТА Карней форм	АТА Карней формыг 10 компанид олгосон.
9	Экспертиз	Давхардсан тоогоор 136 компани нэр дээр агуулах болон гаалийн нэг цэгийн үйлчилгээн дээр 1694 экспертиз/ цаг ажиллаж, 376 акт сертификат монгол, орос, англи хэл дээр хавсралтын хамт боловсруулан бичиж, хүлээлгэн өгч үйлчилсэн байна. Газрын тосны бүтээгдэхүүн импортолдог гэрээт байгууллага М-Ойл компаний 410 вагон/цистерн-д, Ник, Петростар ХХК-ий 689 вагон/цистернд бусад нефтийн компаниудад 265 вагонцистерн-д тооны хэмжилт шалгалт хийсэн байна.
10	Органик бүтээгдэхүүний сертификат	Органик бүтээгдэхүүн/certified organic” шошгыг 5 компаний бүтээгдэхүүнүүдэд олгосон.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Чехийн ЭСЯ-ны орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл:

Чанарын хөндлөнгийн хяналтын үйлчилгээг сайжруулах зорилгоор Монгол улс дахь Чехийн ЭСЯ-ны орон нутгийн хөгжлийг дэмжих төслийн хүрээнд лабораторийн ариутгалын Sterilab ба Stericell хоёр тоног төхөөрөмжийг хүлээн авсан.



Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвийг хөгжүүлэх төсөл:

Европын сэргээн босголтын хөгжлийн банкны санхүүжүүлтээр “БМЭЗ” төв буюу Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааг эхлүүлэх амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд 2 дахь шатны төслийг орон нутаг руу чиглүүлж эхлүүлэх шатандаа явж байна.

Экспортын зөвлөх үйлчилгээний төсөл:

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран Экспортын зөвлөх үйлчилгээний 3 шаттай арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд :

- **I шат:** 5 сарын 1-д Экспортын зөвлөх үйлчилгээ сургалтыг зохион байгуулсан. Сургалтын хүрээнд 40 экспортлогч компаниар анкет бөглүүлэн EBRD олон улсын зөвлөх Ровертоос зөвлөгөө авахуулахаар өгсөн. Тус сургалтад нийт 56 бизнес эрхлэгчид оролцов.
- **II шат:** 5 сарын 21-д EBRD оффис дээр 2 дугаар шатны арга хэмжээ болох Robert эксперттэй онлайн сургалт хамтран хийсэн. Сургалтад өмнөх шатнаас сонгогдсон 20 орчим экспортлогч компаниуд оролцсон. Robert эксперт экспортын бэлэн байдлын үнэлгээ хийх талаар зөвлөгөө өгсөн.
- **III шат:** Онлайн сургалтад хамрагдсан 20 гаруй компанид Robert эксперт Монголд ирэн үнэгүй зөвлөгөө биечлэн өгсөн. Хаалтын арга хэмжээнд оролцсон.

Германы Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимуудын Холбоотой хамтран хэрэгжүүлэх төсөл:

- МҮХАҮТ нь ГХАҮТХ-той хамтран ХБНГУ-ын Эдийн Засгийн Хөгжил, Хамтын Ажиллагааны Яаманд монголын бараа бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх өргөдөл гаргасны дагуу хонины ноос, чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл батлагдсан. Уг шинэ төслийн хүрээнд Архангай аймагт хонины ноос, Увс аймагт чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих чиглэлээр ажиллана. Төслийг 2015.09-2018.08 сар хүртэл 3 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ. 2015 оны 10 сард ноосны болон чацарганы суурь судалгааг хийсэн. 2015 оны 11 сарын 25-26-ны өдрүүдэд төслийн төлөвлөлтийн семинарыг амжилттай зохион байгуулж 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган, ажиллаж эхлээд байна.

Азийн сантай хамтран “Эмэгтэйчүүдэд зориулсан бизнес инкубатор төв” төсөл:

- Азийн сангаас 2016.06 - 2018.06 он хүртэл хэрэгжүүлэх эмэгтэйчүүдэд зориулсан Бизнес инкубатор төслийн хүрээнд танхимын 24 төрлийн сургалтыг 2016 оны 1-р сараас эхлэн явуулахаар болсон.

Экспертүүд:

Танхим дээр ЖАЙКА-ийн шугамаар Японоос Мацумото Такеши хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр экспертээр 1 жилийн хугацаантай ирсэн. Японы зах зээлд нэвтрэх, Японы аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, түншээ хэрхэн олох, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх, танхимын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх зэргээр хамтран ажиллаж байна. Мөн КОТРА-аас 2 эксперт, Азийн сангийн шугамаар АНУ-аас 1 эксперт тус тус ирж ажиллаж байна.

ТАНХИМЫН ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ

Чанарын удирдлагын ISO 9001:2015



ISO 9001-ийг нэвтрүүлэх ажил өнгөрсөн жилийн 3-р сараас эхэлсэн. Танхим дээр болж байгаа болон үйл ажиллагааны үйл явцуудыг тодорхойлолт, замын зургийг эхний байдлаар гаргасан. Мөн журмуудад шинжилгээ хийж, заримыг нь нэгтгэх, шаардлагатай зарим журмыг нэмлээ. Ялангуяа Хөдөлмөрийн дотоод журамд ажлын хэсэг байгуулж нэгдсэн журмаа гаргасан. Одоогоор мэдээллийн системийн менежментийг боловсронгуй болгох, мөн хүний нөөцтэй холбоотой буюу бүртгэлжүүлэлт, ажлын бүтээмжийг үнэлэх, дүгнэх гэсэн ажлын хүрээнд “IT zone”-той хамтарч Green HR системийг нэвтрүүлж эхэлсэн. Мөн энэ жилийн төлөвлөлтийг шинээр хийж танхимынхаа эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлон гаргасан.

Хүний нөөцийн Green HR систем

“Бизнетворк консалтинг” ХХК-тай 2015 оны 11 сараас эхлэн бэлтгэл ажлууд хийгдэж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, байгууллагын үйл ажиллагааны урсгалыг диаграммыг зураглаж,ажил үүргийн хуваарь тодорхой болгох, карьер хөгжил, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ / KPI /, ажлын үр дүнг хэмжигдэхүйц болгохоор зорин ажиллаж ажлын гүйцэтгэл одоогийн байдлаар 80 гаруй хувьтай байна. Мөн бүх бичиг баримт, үйл ажиллагааны журам, зааврууд стандартын дагуу бэлтгэгдэн мөрдөгдөж байна.



Дотоод үйл ажиллагааны автоматжуулалт болон гишүүдийн мэдээлэл, бүртгэл, хяналтын систем

Танхим – Гишүүд, Танхим - Танхим хоорондын уялдаа холбоог сайжруулах, танхимаас үзүүлж буй үйлчилгээг зорилтод бүлгүүдэд хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, дотоод үйл ажиллагаандаа хяналт тавих зорилгоор IT zone ХХК-тай хамтран Дотоод үйл ажиллагааны автоматжуулалт болон гишүүдийн мэдээлэл, бүртгэл хяналтын системийг 2015 оны 4-р сараас эхлэн нэвтрүүлж байна. Танхимын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй Гарал үүслийн гэрчилгээ, гишүүнчлэл, патент, үзэсгэлэн яармаг, сургалт, экспертизийн гэх мэт үйлчилгээнүүдийг бүртгэлжүүлэх, нээлттэй, ил тод, хурдан шуурхай болгох бүртгэлийн системийг нэвтрүүлэх ажил одоогийн байдлаар бүх газар хэлтэстэй уулзалт хийж, судалгаа явуулан, ерөнхий мэдээллээр хангах сургалтууд явагдсан байна. Мөн Гишүүнчлэлийн бүртгэлийн системийг турших шатандаа явагдаж байна.

САЛБАР ТАНХИМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Үндэсний хэлэлцүүлэг:

МҮХАҮТ-аас анх удаа санаачилан гаргаж байсан Үйлдвэржилтийн газрын зургийг шинэчлэн гаргах, орон нутагт ЖДҮ-ийг дэмжих чиглэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг оновчтой, төр хувийн хэвшлийн хэлцлийн үндсэн дээр төлөвлөх, үндэсний шилдэг бараа бүтээгдэхүүн, брэндүүдийг бий болгон өргөжүүлэх, үйлдвэржилтийн талаарх төрийн бодлого, төлөвлөгөө, хуулиудад бизнес эрхлэгчдийн санал, бодлыг тусгуулах зорилгоор “Үндэсний хэлэлцүүлэг” –ийг 2015 оны 3 сарын 19-нд 21 аймагт нэгэн зэрэг амжилттай зохион байгуулсан. Нийт 3 сэдвээр хэлэлцүүлэг явуулсан бөгөөд сэдэв тус бүрийн тайланг нэгтгэн, боловсруулсан. Үүнд:

1. “Орон нутагт хөгжүүлэх хэрэгцээтэй ЖДҮ-г тодорхойлох” сэдвээр явуулсан хэлэлцүүлгийн үр дүнд орон нутагт 145 чиглэлээр 378 үйлдвэрийг хөгжүүлэх хэрэгцээтэй ба үүний 78% нь боловсруулах болон ХАА салбарынх гэсэн дүгнэлт гарсан.
2. “Аймгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ ба тэдгээрийн зах зээл” сэдвээр явуулсан хэлэлцүүлгийн үр дүнд 17 салбарын 205 брэнд бүтээгдэхүүнийг тодорхойлсон ба үүний 70 % нь хүнс, аялал жуулчлал, сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн байв.
3. “ЖДҮ-д тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох” сэдвээр явуулсан хэлэлцүүлгээр
 1. Санхүүгийн хүндрэл бэрхшээл
 2. Хүний нөөцийн хомсдол зэрэг 7 хүндрэл бэрхшээлийг тодорхойлсон.

Бизнесийн холбоодыг хөгжүүлэх төсөл:

Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа Бизнесийн холбоодыг хөгжүүлэх төсөлд Сэлэнгэ, Завхан, Дархан, Дорнод, Эрдэнэт, Өвөрхангай, Хөвсгөл гэсэн 7 аймгийн салбар танхимууд хамрагдаж, сургалтанд оролцон зөвлөх үйлчилгээг авч байна.

Зээлийн батлан даалтын сангийн орон нутгийн төлөөлөл:

ЗБДС-тай хамтран ажиллах санамж бичиг зурсны дагуу Архангай, Баян-Өлгий, Орхон, Говьсүмбэр, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Сүхбаатар, Төв зэрэг 9 аймагт сангийн төлөөлөгчөөр салбар танхим ажилласан.

Бүтээлч нэг сарын аян:

Танхимын 55 жилийн ойг тохиолдуулан Салбар танхимын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх шинэ санаачилгыг дэмжин урамшуулах, шинийг санаачлагч бүтээлч Салбар танхимыг шалгаруулах зорилгоор «Бүтээлч нэг сарын аян»-ыг 5-р сарын 05-наас 6-р сарын 05-ны хооронд 1 сарын хугацаанд зохион байгуулсан. Нийт 13 Салбар танхимаас тайлан ирсэн ба Завхан аймаг дахь ХАҮТ, Дархан-Уул аймаг дахь ХАҮТ, Увс аймаг дахь ХАҮТ ба Өмнөговь аймаг дахь ХАҮТ тус тус шалгарлаа.

Салбар танхимыг чадавхжуулах сургалт:

Модератор хийх, баримт бичгийн стандарт, анхан шатны баримт бүрдүүлэлт, ерөнхий журнал хөтлөлт, НДШ-н тайлан, цалин бодолт ба татварын тайлан гэсэн сэдвүүдээр үндэсний танхимаас онлайн сургалтуудыг зохион байгуулсан. Онлайн сургалтыг тогтмол, чанартай хийх бололцоог хангах зорилгоор микрофонтой видео камераар салбар танхимуудыг хангасан.

САЛБАР ТАНХИМ

ЗОХИОН БАЙГУУЛСАН ТОМООХОН АРГА ХЭМЖЭЭНҮҮД:

21 аймаг дахь салбар танхимууд 2015 онд нийт 30 гаруй томоохон арга хэмжээг орон нутагт зохион байгуулсан байна.

Эдгээрээс дурдвал:

1. Баянхонгор сумын бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн
2. Говь-Алтай аймаг дахь салбар танхим “Хөдөлмөрийн бага” чуулган
3. Говь-Алтай аймаг дахь салбар танхим Хоршоологчдын чуулган, үзэсгэлэн
4. 2014 оны Дархан-Уул аймгийн ТОП-5 ААН шалгаруулах ёслолын ажиллагаа
5. Улаанбаатар - Дархан - Орхон бизнес аялал
6. Дорнод аймаг дахь салбар танхим, БНХАУ-ын ӨМӨЗО-ны, Хөлөнбуйр хот хамтран Хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга уулзалт
7. Дорнод аймаг дахь салбар танхим Их Түмэн санаачилгын Зүүн хойд Азийн орнуудын Орон нутгийн хамтын ажиллагааны хорооны 3 дугаар бага хурал
8. Завхан аймаг дахь салбар танхим “Завхан аймгийн маа-н гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөөц, боломж” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал
9. “Эрдэнэт үйлдвэрлэл, технологийн парк хөрөнгө оруулагчдын чуулган-2015”
10. “Зөөлөн оёдлын салбарын бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”
11. “Бизнес ногон гэрэл асаацгаая” уриан дор орон даяар явагдсан Бизнес фестиваль
12. Аймгийн тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн
13. Өвөр байгалын хязгаарын Чита хотноо “Хил залгаа бүс нутгийн хамтын ажиллагааг ил болгох сэдэвт” Олон улсын хамтын ажиллагааны бизнес форум уулзалт
14. Говь-Алтай аймаг дахь салбар танхим Их говийн тэмээний баяр 2015 арга хэмжээ зохион байгууллаа.
15. Баянхонгор аймгийн Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны анхдугаар хуралдааныг зохион байгууллаа.
16. Өвөрхангай аймаг дахь салбар танхим “Орон нутагт нийгмийн түншлэлийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалт зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд Засаг дарга Тогтохсүрэн, МАОЭНХ –ний дэд ерөнхийлөгч гүйцэтгэх захирал Х.Ганбаатар Аймгийн ҮЭХ –ны дарга Баярбат Аймгийн АОЭХ тэргүүн Батмөнх нар оролцон 201 хүнд хийсэн ажлын талаар дэлгэрэнгүй танилцууллаа.
17. Өвөрхангай аймгийн Бизнесийн салбарт манлайлагч тэргүүлэгч эмэгтэйчүүдэд урам хайрлан, өөрсдөөрөө бахархан омогших сэтгэлийг төрүүлэх зорилго бүхий уламжлалт “Эрхэмсэг бүсгүйчүүд” цэнгээнт арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд аймгийн удирдлагууд оролцон амжилт хүсч хүндэтгэл илэрхийллээ. Цэнгүүнд сум сумдын шилдэг 120 эмэгтэй оролцлоо.
18. Хэнтий аймаг дахь салбар танхим Аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтарч “Амжилтын гараа – 2015” хөдөлмөрийн яармаг, өдөрлөгийг зохион байгуулав.

“Увс аймаг дахь салбар танхим”-ын 10 жилийн ойн арга хэмжээ

МҮХАҮТ-ын 55 жил Увс аймгийн 90 жилийн ойн Улсын үзэсгэлэн худалдааг 2015 оны 6 сарын 3-аас 8 ны хооронд Улаангом суманд зохион байгуулагдлаа. Салбар танхим нь 10 жилийн ойн арга хэмжээний хүрээнд олон Улсын үзэсгэлэн худалдаа Улаангомд зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд

Хятадын ШУӨЗО-ны 40 компани өөрийн орны бүтээгдэхүүнээр оролцлоо. Хятадын талаас төр засгийн болон хувийн хэвшлийн 78 төлөөлөгчид, ОХУ-ын Тыва Улсаас 38 төлөөлөгч Тыва Улсын үндэсний телевизийн сурвалжлагч сэтгүүлч нар оролцлоо.

“Зүүн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2015 - Хөгжлийн төлөө түншлэл” арга хэмжээ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс 2015 оны 10-р сарын 08-09 – ний өдрүүдэд Сүхбаатар аймаг дахь ХАҮТанхимтай хамтран “Зүүн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2015-Хөгжлийн төлөө түншлэл” арга хэмжээг Сүхбаатар аймгийн

Баруун-Урт хотод зохион байгууллаа. Хуралд зүүн бүсийн гурван аймгийн удирдлага, бизнес эрхлэгчид, Улаанбаатар хотоос Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ЗГХЭГ, салбарын яамд зэрэг байгууллагуудаас шийдвэр гаргах түвшний төлөөллүүд оролцсон.

ХАМТЫН АЖИЛЛАГАА:

Хамтын ажиллагааны санамж бичиг:

Монгол улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглалын хүрээнд 10 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөххотноо зохион байгуулагдсан Хятад-Монголын анхдугаар экспо арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан Монгол-Хятадын Худалдаа аж үйлдвэрийн танхимуудын дээд хэмжээний уулзалтын үеэр 16 Салбар танхим БНХАУ-ын 12 Салбар танхимтай 30 гаруй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.

2015 оны 8 сарын 9 ний өдөр ШУӨЗО-ны Алтай аймаг Хөх тохой суманд Хятад, Орос, Монгол, Казакстан Улсын 7-н ХАҮТанхим нь Олон Улсын хамтын ажиллагааны ТУНХАГ БИЧИГТ гарын үсэг зурлаа. ХАҮТанхимууд нь найрсаг, эрх тэгш харилцан эдийн засгийн ашиг орлого нэмэгдүүлэх өөрийн орны бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, Олон Улсын үзэсгэлэн худалдааг ХАҮТ-ууд өөрийн Улс орон аймагтаа ээлж ээлжээр зохион байгуулахаар ТУНХАГ БИЧИГТ тусгагдсан.

Уулзалт:

Салбар танхимаас 3 салбар танхим ХБНГУ, БНСУ, БНХАУ зэрэг 3 орны төр хувийн хэвшлийн төлөөлөлтэй хөрөнгө оруулалтын салбарт хамтран ажиллах зэрэг болон бусад асуудлаарх 6 бизнес уулзалт, өдөрлөгт оролцов .

Эдгээрээс онцолбол:

1. Баянхонгор аймгийн салбар танхимын төлөөлөл Германы Берлин хотноо “Kommunale Wirtschaftsförderung in Deutschland” сэдэвт уулзалтанд оролцсон
2. Төв аймгийн салбар танхимтай хамтран БНХАУ-ын Ляонин мж, Жилин мужийн бизнес эрхлэгчдийн төлөөлөл Зуунмод суманд бизнес өдөрлөг, ганцаарчилсан уулзалт хийсэн
3. Дархан-Уул аймгийн салбар танхим Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Жижиг Дунд Бизнесийг дэмжих хөтөлбөртэй хамтран бизнес эрхлэгчдэд зориулсан бизнесийн зөвлөх үйлчилгээний үр ашиг, ач холбогдлыг сурталчлан, таниулах KnowHow, компаниудын удирдлагуудад зориулсан менежментийн сүүлийн үеийн мэдлэг, мэдээллийг өгөх уулзалтуудыг зохион байгуулж 65 аж ахуй нэгжийн төлөөлөл оролцов .

Сургалт:

Баянхонгор аймгийн салбар танхим Самэул ТББ-ын шугамаар БНСУ-д ХАА-н чиглэлээр сургалтанд хамрагдаж, Ёожүгийн сургууль дээр Хүлэмжийн аж ахуй, өвлийн хүлэмжинд дадлага хийв. Сургалтаас ирээд сурсан мэдсэнээ бизнес эрхлэгчиддээ танилцууллаа. 2016 онд 10 бизнес эрхлэгчийг хамруулахаар боллоо.

БИЗНЕС УУЛЗАЛТ

МҮХАҮТ-ын 17 аймаг дахь салбар танхимуудын тайлант мэдээгээр Гадаад болон Дотоодод нийт давхардсан тоогоор 50 орчим бизнес уулзалтуудыг зохион байгуулж гадаадад зохион байгуулагдсан уулзалтанд 96 бизнес

эрхлэгч, дотоодод зохион байгуулагдсан бизнес уулзалтанд 970 бизнес эрхлэгчийг хамруулж хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласан. Үүнээс дурдвал:

Гадаадад:

1. Говь-Алтай аймаг дахь салбар танхим нь БНХАУ-ын Хами аймагт хийсэн бизнес аялалд танхимын гишүүн байгууллагын төлөөлөл 8 хүн оролцуулж Хами аймгийн бизнес болоод бусад газруудын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан.
2. ӨМӨЗО-ны Эзнээ хошуу Цэхээ боомтын удирдлагууд Өмнөговь, Баянхонгор аймгийн удирдлагууд, ХАҮТанхимын төлөөлөл, бизнес эрхлэгчдийг хүлээн авч, бизнес уулзалт зохион байгуулж хамтын ажиллагаагаа бэхжүүлэв.
3. Хэнтий аймаг дахь салбар танхим Аймгийн Засаг Даргын мөрийн хөтөлбөрийн ажлын хүрээнд Аймгийн ЗДТГазар, Хөдөлмөрийн хэлтэс, Залуучуудын холбоо, Хүүхэд Гэр бүл хөгжлийн хэлтэс, Дэлхийн Зөн ОУ-н байгууллагатай хамтарч Улаанбаатар хот, ОХУ-н Буриадын Улан – Үдэ - Итгэлт хамба Байгаль нуурын бизнес аялал, уулзалт, сургалт зохион байгуулагдав. Уг бизнес аялалд 42 бизнес эрхлэгчид оролцов.

4. Өвөр байгалийн хязгаарын Чита хотноо “Хил залгаа бүс нутгийн хамтын ажиллагааг ил болгох” сэдэвт хамтын ажиллагааны форумд оролцож Хэнтий аймгаас 6 бизнес эрхлэгчид хамрагдав.

Дотоодод:

1. “Орон нутгийн цогц хөгжил-Түншлэл” төслийн хүрээнд Баянхонгор аймгийн ЖДҮ ба Уул уурхайн компаниудын анхны уулзалт
2. Говь-Алтай аймаг дахь салбар танхим нь “АМЖИЛТЫН ГАРАА” Өдөрлөгийн үеэр иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг 110 гаруй иргэнд зохион байгуулсан.
3. Төрийн ордонд болсон “Зуун дамжсан баялаг бүтээгч” чуулганд Өвөрхангай аймгаа төлөөлөн 21 бизнес эрхлэгч эмэгтэйчүүд оролцсон.
4. Өмнөговь аймаг дахь салбар танхим “Бизнесийн орчин дахь авлигын нөхцөл байдал” сэдвээр цахим хэлэлцүүлэг зохион байгуулж 15 аж ахуй нэгжийг хамруулан санал бодлоо солилцсон.
5. Өмнөговь аймагт Ерөнхий сайдын айлчлалын үеэр орон нутгийн бизнесийн салбар бүрээс 100 гаруй төлөөллийг сайдтай уулзуулж, санал бодлыг хүргүүлсэн.
6. Баянхонгор аймгийн Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны анхдугаар хуралдаан
7. “Булган аймгийн Барилгын салбарын тулгамдсан асуудал” хэлэлцүүлэг
8. “Монгол улсын газрын тосны салбарын өнөөгийн байдал ба хэтийн төлөв” сэдэвт зөвлөгөөн
9. Сүхбаатар аймгийн бизнесменүүдийн нэгдэл группын уулзалт

Чех-Монголын бизнес уулзалт:

Дархан - Уул аймагт Чех - Монголын бизнес уулзалтыг 2015 оны 09 сарын 24-нд Аймгийн ЗДТГазрын хурлын танхимд зохион байгууллаа. Тус хуралд Чех улсаас 20 орчим бизнес төлөөлөгч, Дархан-Уул аймгийн 24 бизнесийн төлөөлөл оролцож, Чехийн бизнесийн төлөөллүүд компани бизнесийнхээ

талаар танилцуулга хийж, Дарханы бизнесүүд сонирхсон асуултуудаа асууж, хамтарч ажиллах боломж нөхцлийн талаар санал солилцлоо. Энэ үеэр Монгол Улсад суугаа БНЧУ-ын элчин сайд Хатагтай И. Гроллова хүрэлцэн ирж Дархан-Уул аймгийн удирдлагуудтай уулзлаа.

ҮЗЭСГЭЛЭН

2015 онд нийт 17 аймгийн салбар танхим нийт ОХУ, Унгар, БНХАУ зэрэг 4 улсын 7 хотуудад 8 удаагийн үзэсгэлэнг зохиов н байгуулж 154 гишүүн байгууллагуудаа хамруулсан.

Дотоодод 56 удаагийн үзэсгэлэн зохион байгуулж 1870 бизнес эрхлэгчдийг хамруулсан. Томоохон үзэсгэлэнгээс дурдвал:

“Монгол - Хятадын анхдугаар Экспо”

“Монгол-Хятадын анхдугаар ЭКСПО 2015” арга хэмжээний үзэсгэлэнд нийт 23 хэсэг ажилласан ба үүнд Монгол Улс, нийслэл Улаанбаатар хот, 21 аймгийн сурталчилгаа явагдсан. Үзэсгэлэнд Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Ховд, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Булган, Дорноговь аймгуудыг төлөөлж МҮХАҮТ-ын салбар ХАҮТанхимууд идэвхи зүтгэлтэй

оролцож Монгол Улсаа сурталчиллаа. Монгол-Хятадын анхдугаар экспо 2015 арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан Монголын бараа бүтээгдэхүүнийг сурталчилах үзэсгэлэнд орон нутгаас давхардсан тоогоор 30 ААНэгж амжилттай оролцоод ирсэн.

Гадаад үзэсгэлэн

1. Хятадын Бугат хотын Тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн 2 дахь удаагийн экспо үзэсгэлэн худалдаа
2. БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймгийн ХӨХ Тогай суманд зохион байгуулагдсан Алтай бүсийн үзэсгэлэн худалдаа
3. ОХУ-ын Эрхүү хотын үзэсгэлэн худалдаа
4. ӨМӨЗО-ны Альшаа аймаг, Эзнээ хошуу, Цэхээ боомт “Цагаан сараа угтах баяр” хилийн худалдаа
5. Баян-Өлгий ХАҮТ нь ОХУ-ын Алтайн БНУ-ын Кош-Агаш мужийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан үзэсгэлэн

Дотоод үзэсгэлэн

1. Баянхонгор, Булган, Говь-Алтай, Төв, Говьсүмбэр, Дархан-уул, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь **9** салбар танхимууд **Цагаан сар** үзэсгэлэнг зохион байгуулж давхардсан тоогоор **745** бизнес эрхлэгчид оролцож өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ сурталчлан борлуулсан.
2. Говь-Алтай, Говьсүмбэр, Орхон, Өвөрхангай, Төв, Завхан, Хөвсгөл, Булган, Сүхбаатар аймаг дахь **9** салбар танхим **“Түншлэл”** үзэсгэлэнгээ зохион байгуулж **697** бизнес эрхлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнээ борлуулсан.

Бусад

1. Баян-Өлгий аймгийн салбар танхим ОХУ-ын Алтайн БНУ-ын Кош-Агаш мужийн удирдлагуудтай хамтран 3 удаагийн үзэсгэлэн
2. “Говийн бүсийн” үзэсгэлэн худалдаа
3. Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Дорнод, Хэнтий аймаг дахь салбар танхимууд “Намрын ногоон өдрүүд-2015” үзэсгэлэн худалдаа
4. Баянхонгор аймаг дахь салбар танхим “Үндэсний хямдралын үзэсгэлэн
5. Булган, Дархан, Хөвсгөл аймаг дахь салбар танхимууд “Хаврын гоёл” үзэсгэлэн худалдаа
6. Стандарт хэмжилзүйн хэлтэс, Хүнс ХАА-н газар, АОЭХ, Худалдаа эрхлэгчдийн холбоотой хамтран Худалдаа эрхлэгчидийн өдрийг “Хямдралын өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлээ.
7. Дорнод аймагт Барилгын үзэсгэлэн яармаг
8. Дорнод экспо-2015” олон улсын үзэсгэлэн худалдаа 80 хүн
9. Завхан “Хичээлийн шинэ жил” үзэсгэлэн худалдаа 16 хүн
10. Улаанбаатар хотноо “Мишээл Экспо” үзэсгэлэнгийн төвд Дорнод аймаг болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн “Органик ногоон бүтээгдэхүүн, Аялал жуулчлал-2015” үзэсгэлэн худалдаа, Хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны хоёрдугаар чуулга уулзалт
11. Төв аймаг “Нэг сум нэг бүтээгдэхүүн ” намрын үзэсгэлэн худалдаа
12. Жимс, модны үрсэлгээ 2015 үзэсгэлэн худалдаа
13. “Говь фестиваль-2015” үзэсгэлэн худалдаа
14. “Увсад үйлдвэрлэв” барааны үзэсгэлэн худалдааг тус тус зохион байгуулсан.

СУРГАЛТ

2015 онд **17** салбар танхим орон нутагт **68** удаагийн сургалт зохион байгуулж **765** хүн сургалтанд хамруулсан байна. Үүнээс товч дурдвал

1. “Авилгатай тэмцэх ба Ил тод байдал” сэдэвт сургалт
2. Бизнесээ хэрхэн эхлэх вэ? сургалт
3. Санхүүгийн боловсролын нэг өдрийн сургалт
4. “Нийтийн хоолны салбарын хөгжил, тэдгээрийн чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалт
5. Увс аймаг дахь салбар танхим
 - Хоршооны дарга менежерийн сургалт
 - санхүүгийн сургалт
6. Иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт
7. “Стандарт, түүний ач холбогдол”, “Тохирлын үнэлгээний суурь асуудал”, “Хүнсний бүтээгдэхүүнийг мэдрэхүйн аргаар таних нь” зэрэг сэдвүүдээр танин мэдэхүйн сургалт,
8. Дэлхийн бизнесийн өнөөгийн чиг хандлага, Бизнес санаагаа үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлэх талаарх сургалт
9. “Тендер боловсруулах чадамжийг дээшлүүлэх” сургалт
10. “Хэрэглээнд суурилсан дулааны тарифийн системийг хөгжүүлэх боломж” сургалт

СУДАЛГАА

Нийт 17 салбар танхим 39 төрлийн судалгааг 5470 судалгааг хүнээс авч үр дүнг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлсэн байна.

1. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс МҮХАҮТ болон орон нутаг дахь салбар танхимуудтай хамтран 4 дахь жилдээ авч буй аймгуудын өрсөлдөх чадварын судалгааг 19 салбар танхим эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төвөөс аймгуудын өрсөлдөх чадвар хөгжлийн түвшинг харуулах удирдаржийн дагуу аймагт үйл ажиллагаа явуулж буй тус бүр 50-аад томоохон төрөл бүрийн бизнесийн байгууллагын удирдах ажилтануудаар бөглүүлэн хүргүүлсэн.
2. Дархан-Уул аймгийн ШШГА-ны үйлчилгээ, үйл ажиллагааны өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж байгааг зорилтод бүлэг түүний ар гэр, иргэдийн саналыг авч хөндлөнгийн дүгнэлт гаргах зорилгоор ДАРХАН ХАҮТ-ын дэргэдэх судалгааны баг 2014 оны дөрөвдүгээр улиралд судалгааг анкетын асуулгаар, санамсаргүй байдлаар түүвэрлэх аргаар 201 оролцогчийг / зорилтод бүлэг 91, иргэд 110 /хамруулан spss программыг ашиглан дүгнэлээ. шшгалбаны өмнөх улирлуудын судалгааны дүн мэдээг харьцуулан авч үзэхэд ШШГГалбаны зорилтод бүлэг болон үйлчилгээ авсан иргэд үйл

ажиллагаа үйлчилгээний талаар мэдлэг мэдээлэлтэй харин энгийн иргэд үйл ажиллагаа үйлчилгээг нь тэр бүр мэдэхгүй байгаа тул энэ удаагийн судалгаанд энгийн иргэдийг илүү хамруулав.

3. Завхан аймагт худалдаа үйлчилгээ явуулж буй бизнес эрхлэгчдийг нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх боломжийг бүрдүүлэх зорилгоотойгоор доорхи 5 бүтээгдэхүүнд зах зээлийн багтаамжын судалгааг танхим, аймгийн ИТХ, МУИС-ын завхан сургуулийн баруун бүсийн судалгааны төв хамтран хийлээ.
4. Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа, үзэсгэлэн худалдаануудад оролцогчдын сэтгэл ханамжийн судалгаа, бизнес хөгжлийн төвд үйл ажиллагаа явуулагсдын үйл ажиллагааны талаарх судалгаа, өвөрхангайд үйлдвэрлэв төвийн үйл ажиллагааны талаар болон нутгийн брэнд бүтээгдэхүүний хөгжил зэрэг нийт 8 удаагийн судалгаа авч 1200 гаруй хүнийг хамрууллаа.
5. Трант ххк нь start center нэрээр япон сэлбэгийн худалдаа, засвар үйлчилгээний чиглэлд судалгаа авав.
6. Бизнесийн итгэлийн индекс судалгааг 8 аймгаас тус бүр 50 бизнес эрхлэгчидээс авсан.

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

GIZ – Германы Олон Улсын Хамтын ажиллагааны нийгэмлэг: Баянхонгор аймаг дахь салбар танхим нь Германы Олон Улсын Хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөртэй хамтран “Орон нутгийн цогц хөгжил-4” төслийг хэрэгжүүлээд байна.

Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Үр дүнтэй холбоодыг хөгжүүлэх-2015 хөтөлбөрийн Бизнесийн холбоодыг чадавхижуулах нь төсөлд 7 салбар танхим хамрагдан төслийг хэрэгжүүлж байна. Энэ онд шинээр 2 танхим нэмэгдэж төсөлд хамрагдахаар болсон.

МҮХАҮТ, Германы ХАҮТ-уудын холбоотой хамтын ажиллагааны төсөлд Архангай аймаг дахь салбар танхим, Увс аймаг дахь салбар танхимууд шалгарч ноос ноолуур, чяцарганы төсөл хэрэгжихээр судалгаа хийгдсэн.

Бусад:

- ✓ Care program-Халамж хөтөлбөр. Дархан-Уул аймаг дахь салбар танхим нь сүүлийн

жилүүдэд гишүүний хураамжаа төлөөгүй болон үйл ажиллагаанд оролцдоггүй зарим гишүүн байгууллагуудыг сонгон авч нөхөрсөг байдлаар буюу “Care program-Халамжлах хөтөлбөр”-ийг санаачилан 2015 онд амжилттай хэрэгжүүлсэн.

- ✓ Органик Монгол Хөтөлбөр: Хөтөлбөр зарлагдсаны дагуу 17 төсөл ирснээс 135 сая төгрөгийн санхүүжилт хүссэнээс эхний шатны шалгаруулалтаар 13 төсөлд 120 сая төгрөгийг дэмжихээр болсон.Төслийн 2 дахь шатны шалгаруулалтаар 12 төсөлд 109 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэж банк руу хүргүүлсэн. Банк судалснаар 11 төсөлд 80,8 сая төгрөгийн зээл олголт хийлээ.
- ✓ DAP хөтөлбөр: БНСУ-д дахь Австрали улсын элчин сайдын яамнаас зарласан Австралийн Засгийн Газрын Шууд Тусламжийн хөтөлбөрийн төслийн уралдаанд Дархан аймаг дахь ХАҮТ-аас “Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, инновацийг дэмжих” хөтөлбөр бодлогын баримт бичиг төсөлд материалаа явууллаа.

БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ

Нэгдсэн Бодлого Төлөвлөлт, Зохицуулалтын Газар policy@mongolchamber.mn	Утас: 310619
Бизнес, Гадаад Худалдаа Сургалт, Судалгааны Газар training@mongolchamber.mn	Утас: 324258
- Гадаад Худалдааны Академи - Талх, нарийн боовны сургалт - Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн бэлтгэх сургалт - Компьютерийн сүлжээний мэргэжилтэн бэлтгэх сургалт	
GS1 Монгол нийгэмлэг barcode@mongolchamber.mn	Утас: 313411
Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитр arbitr@mongolchamber.mn	Утас: 70111545
Бизнесийн Маргааныг Эвлэрүүлэн Зуучлах Төв bmez@mongolchamber.mn	Утас: 70111545
Гишүүнчлэлийн Газар membership@mongolchamber.mn	Утас: 324394
Маркетинг, Олон Нийтэй Харилцах Газар marketing@mongolchamber.mn	Утас: 70109090
- "Бизнес ба Хөгжил" сэтгүүл - "Invest Pro Mongolia" сэтгүүл - "Бизнес Таймс" сонин businessstimes@mongolchamber.mn	Утас: 325374
Жижиг Дунд Үйлдвэр, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Газар sme@mongolchamber.mn	Утас: 314000
- Нэг Цэгийн Үйлчилгээний Төв - "Air Chamber" билетийн касс	Утас: 323974, 99022590
Гадаад Харилцаа, Хамтын Ажиллагааны Газар munkhbat@mongolchamber.mn	Утас: 312501
Экспортыг Дэмжих Хөгжүүлэх Газар export@mongolchamber.mn	Утас: 328878
Үзэсгэлэн, Яармагийн Газар exhibition@mongolchamber.mn	Утас: 312371
Патент, Барааны Тэмдэг, Газар Зүйн Заалтын Газар patenttmbur@mongolchamber.mn	Утас: 310396
Цэвэр Хөгжил, Цэвэр Үйлдвэрлэлийг Дэмжих Газар esco@mongolchamber.mn	Утас: 329167
Экспорт, Импортын Барааны Магадлан Шалгах Газар expertiz@mongolchamber.mn	Утас: 322145
Захиргаа, Хүний Нөөцийн Газар hr@mongolchamber.mn	Утас: 329856
Санхүү Тайлан Бүртгэлийн Хэлтэс finance@mongolchamber.mn	Утас: 324353
Аж Ахуйн Хэлтэс	Утас: 318785

Монгол Улс, Улаанбаатар хот 17011,
Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
Махатма Гандигийн гудамж,
МҮХАҮТ-ын байр

Утас: 327176, Факс: 324620

 www.mongolchamber.mn

 chamber@mongolchamber.mn

ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ:

 /mongolchamber

 /mongolchamber

 /mongolchamber

 /MNCCI

ANDROID APPLICATION:

